

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261628 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас:51-261628 Цахим хаяг: Bayarmaao@audit.gov.mn Аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: Bujinlkhandj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Б.ЭРДЭНЭТУЛГА  
ТАНАА

2024.02.23 № 07/274  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Шүүхийн ерөнхий зөвлөл 2023 онд нийт 544,505.4 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлснээс Сангийн сайдын 2023 оны 234 дүгээр тушаалаар давсан 212,081.9 мянган төгрөгийн орлогыг зарцуулах эрхийг олгож, нэмэлт санхүүжилтийн дансанд 129,581.9 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан. Төсвийн гүйцэтгэлийн тайланд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 212,081.9 мянган төгрөгөөр буюу зарцуулах эрх олгосон дүнгээр бууруулан тайлагнасан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд Германы олон улсын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлсэн “Шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чадавхыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 295,839.8 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 124 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 92.1 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	622,902,588.00	393,597,771.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,000,000.00	1,088,101.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	13,000,000.00	1,088,101.00
31210	Төгрөг	13,000,000.00	1,088,101.00
31211	Төрийн сангийн харилцах	13,000,000.00	1,088,101.00
33	АВЛАГА	295,839,792.00	21,060,309.91
33300	Татаас, санхүүжилтийн авлага	295,839,792.00	-
33500	Бусад авлага	-	21,060,309.91
33510	Байгууллагаас авах авлага	-	21,060,309.91
35	БАРАА МАТЕРИАЛ	314,062,796.00	371,449,360.15
35400	Хангамжийн материал	314,062,796.00	371,449,360.15
35410	Бичиг хэргийн материал	61,705,509.00	38,919,319.00
35420	Аж ахуйн материал	188,481,024.00	277,166,878.15
35430	Сэлбэг хэрэгсэл	45,790,000.00	40,655,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,352,100.00	6,315,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,734,163.00	8,393,163.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,583,424,534.91	12,556,893,847.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,583,424,534.91	12,556,893,847.81
39200	Биет хөрөнгө	10,684,110,770.50	10,443,726,399.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,271,310,987.50	9,271,310,987.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(867,068,469.57)	(1,083,250,359.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,240,647,200.00	1,230,560,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,186,913,866.72)	(1,183,026,666.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,726,530,928.50	4,059,304,386.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,916,574,277.08)	(2,200,363,752.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	900,166,463.12	790,293,158.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(550,987,927.21)	(505,594,072.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	47,898,700.00	46,878,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(41,752,295.16)	(43,239,308.75)
39217	Ном	60,853,327.12	60,853,327.12
39300	Биет бус хөрөнгө	1,899,313,764.41	2,113,167,448.28
39301	Програм хангамж	345,345,390.00	565,076,390.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(320,268,445.59)	(334,820,806.72)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,874,236,820.00	1,882,911,865.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,206,327,122.91	12,950,491,618.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,206,327,122.91	12,950,491,618.87
51	Засгийн газрын хувь оролцоо	13,206,327,122.91	12,950,491,618.87
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,646,495,144.95	2,646,495,144.95
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,646,495,144.95	2,646,495,144.95
51200	Хуримтлагдсан үр дүн	7,915,527,991.29	7,659,692,487.25
51210	Өмнөх үеийн үр дүн	7,789,255,950.70	7,915,527,991.29
51220	Тайлант үеийн үр дүн	126,272,040.59	(255,835,504.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,303,986.67	2,644,303,986.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,206,327,122.91	12,950,491,618.87

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,499,037,437.31	6,372,197,403.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	939,371,551.31	1,085,069,836.25
120	Нийтлэг татварын бус орлого	939,371,551.31	1,085,069,836.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	262,473,494.23	421,298,450.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	262,473,494.23	414,923,450.10
120009	Бусад орлого	-	2,845,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	562,348,148.36	594,822,685.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	114,549,908.72	72,478,701.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,559,665,886.00	5,287,127,567.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,078,132,054.00	5,151,414,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,078,132,054.00	5,151,414,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	481,533,832.00	135,713,467.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	332,599,764.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,934,068.00	135,713,467.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,286,870,280.03	6,548,508,079.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,286,870,280.03	6,548,508,079.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,772,985,642.38	6,191,173,641.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,522,542,047.18	3,534,398,885.39
210101	Үндсэн цалин	1,733,531,579.13	2,100,471,886.90
210102	Нэмэгдэл	488,085,678.40	685,762,159.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,699,541.41	360,244,023.06
210104	Урамшуулал	136,225,248.24	387,920,815.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,069,969.00	445,786,915.41
210201	Тэтгэврийн даатгал	217,997,317.67	325,151,921.37
210202	Тэтгэмжийн даатгал	25,003,573.79	31,198,935.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,746,150.64	24,514,749.16
210204	Ажилгүйдлийн даатгал	4,873,272.91	5,680,801.17
210205	Эрүүл мэндийн даатгал	48,449,653.99	59,240,508.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,662,249.36	240,655,994.65
210301	Гэрэл, цахилгаан	81,785,773.92	66,061,094.43
210302	Түлш, халаалт	12,154,349.23	9,984,197.22
210303	Цэвэр, бохир ус	9,722,126.21	11,367,703.00
210304	Байрны түрээс	120,000,000.00	153,243,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	389,014,842.00	483,630,800.85
210401	Бичиг хэрэг	91,855,377.83	140,204,020.00
210402	Тээвэр, шатахуун	66,559,599.00	81,103,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,349,936.43	32,686,396.85
210404	Ном, хэвлэл	32,270,800.00	740,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,110,000.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,503,135.78	10,720,074.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	64,782,832.00	196,721,118.00
210408	Бараа материал акталсны зардал	23,583,160.96	20,655,292.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,403,779.00	91,428,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,000.00	3,440,000.00
210604	Урсгал засвар	40,193,779.00	87,988,050.00
2107	Томиллолт, зочны зардал	34,825,765.00	112,589,090.00
210702	Дотоод албан томиллолт	34,825,765.00	112,589,090.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	264,901,215.00	394,488,148.00

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,125,361.00	354,875,592.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,834,960.00	12,495,690.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,092,321.00	1,977,037.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	544,500.00	498,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	7,138,912.00
210807	Газрын төлбөр	21,304,073.00	17,502,917.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	980,565,775.84	888,195,757.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,739,274.00	89,163,397.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	271,380,464.00	63,313,216.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	691,446,037.84	735,719,144.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	513,884,637.65	357,334,437.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,111,654.00	129,760,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,756,839.00	18,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,354,815.00	111,760,050.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	292,772,983.65	145,074,387.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	292,595,745.65	142,638,173.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	177,238.00	2,436,214.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,000,000.00	82,500,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,000,000.00	82,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	212,167,157.28	(176,310,676.20)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,895,116.69	79,524,827.84
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	262,818.69	79,524,827.84
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	83,928,811.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,703,487.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	126,272,040.59	(255,835,504.04)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,125,111,685.23	6,000,735,809.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	275,473,494.23	417,768,450.10
120	Нийтлэг татварын бус орлого	275,473,494.23	417,768,450.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	262,473,494.23	414,923,450.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	262,473,494.23	414,923,450.10
120009	Бусад орлого	13,000,000.00	2,845,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,849,638,191.00	5,582,967,359.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,078,132,054.00	5,151,414,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,078,132,054.00	5,151,414,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	771,506,137.00	431,553,259.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	622,572,069.00	295,839,792.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,934,068.00	135,713,467.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,949,755,255.23	5,818,757,108.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,949,755,255.23	5,818,757,108.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,140,030,825.58	5,456,000,771.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,522,542,047.18	3,534,574,051.30
210101	Үндсэн цалин	1,733,531,579.13	2,100,647,052.81
210102	Нэмэгдэл	488,085,678.40	685,762,159.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	164,699,541.41	360,244,023.06
210104	Урамшуулал	136,225,248.24	387,920,815.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,069,969.00	445,786,915.41
210201	Тэтгэврийн даатгал	217,997,317.67	325,151,921.37
210202	Тэтгэмжийн даатгал	25,003,573.79	31,198,935.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,746,150.64	24,514,749.16

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	4,873,272.91	5,680,801.17
210205	Эрүүл мэндийн даатгал	48,449,653.99	59,240,508.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,151,149.36	240,655,994.65
210301	Гэрэл, цахилгаан	81,725,921.92	66,061,094.43
210302	Түлш, халаалт	12,658,049.23	9,984,197.22
210303	Цэвэр, бохир ус	9,767,178.21	11,367,703.00
210304	Байрны түрээс	120,000,000.00	153,243,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	349,775,447.04	340,866,211.85
210401	Бичиг хэрэг	93,624,909.61	94,156,430.00
210402	Тээвэр, шатахуун	60,837,100.00	78,066,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,005,536.43	33,161,396.85
210404	Ном, хэвлэл	70,968,000.00	22,340,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,339,901.00	112,341,585.00
2105	Нормативт зардал	1,957,200.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,957,200.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,053,039.00	154,751,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,245,500.00	31,244,400.00
210604	Урсгал засвар	71,807,539.00	123,507,560.00
2107	Томилолт, зочны зардал	39,816,615.00	119,919,090.00
210702	Дотоод албан томилолт	34,825,765.00	112,589,090.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,990,850.00	7,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	253,441,215.00	395,065,292.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	218,665,361.00	355,452,736.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,834,960.00	12,495,690.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,092,321.00	1,977,037.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	544,500.00	498,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	7,138,912.00
210807	Газрын төлбөр	21,304,073.00	17,502,917.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	334,224,144.00	224,381,256.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,451,965.00	120,273,317.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	295,772,179.00	104,107,939.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	809,724,429.65	362,756,336.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,111,654.00	135,181,949.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,756,839.00	18,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,354,815.00	117,181,949.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	588,612,775.65	145,074,387.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	292,595,745.65	142,638,173.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	296,017,030.00	2,436,214.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,000,000.00	82,500,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,000,000.00	82,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	175,356,430.00	181,978,701.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	162,356,430.00	193,890,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,356,430.00	193,890,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	162,356,430.00	193,890,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	162,356,430.00	193,890,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(162,356,430.00)	(193,890,600.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	13,000,000.00	(11,911,899.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,000,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,000,000.00	1,088,101.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,789,255,950.70	13,080,055,082.32
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,789,255,950.70	13,080,055,082.32
9	Тайлант үеийн үр дүн	-	-	126,272,040.59	126,272,040.59
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,915,527,991.29	13,206,327,122.91
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,915,527,991.29	13,206,327,122.91
12	Тайлант үеийн үр дүн	-	-	(255,835,504.04)	(255,835,504.04)
13	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,659,692,487.25	12,950,491,618.87

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,433,004,000.00	5,341,199,376.21	91,804,623.79	98.3
УРСГАЛ ЗАРДАЛ	5,433,004,000.00	5,341,199,376.21	91,804,623.79	98.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,393,004,000.00	5,312,939,276.21	80,064,723.79	98.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,551,918,700.00	3,529,125,124.30	22,793,575.70	99.4
Үндсэн цалин	2,216,995,100.00	2,095,198,125.81	121,796,974.19	94.5
Нэмэгдэл	718,556,600.00	685,762,159.76	32,794,440.24	95.4
Унаа хоолны хөнгөлөлт	379,333,600.00	360,244,023.06	19,089,576.94	95.0
Урамшуулал	237,033,400.00	387,920,815.67	150,887,415.67	163.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	448,453,300.00	445,105,799.41	3,347,500.59	99.3
Тэтгэврийн даатгал	336,184,100.00	324,470,805.37	11,713,294.63	96.5
Тэтгэмжийн даатгал	28,067,300.00	31,198,935.46	(3,131,635.46)	111.2
ҮОМШӨ-ний даатгал	22,453,800.00	24,514,749.16	(2,060,949.16)	109.2
Ажилгүйдлийн даатгал	5,613,500.00	5,680,801.17	(67,301.17)	101.2
Эрүүл мэндийн даатгал	56,134,600.00	59,240,508.25	(3,105,908.25)	105.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,481,100.00	240,655,994.65	6,825,105.35	97.2
Гэрэл, цахилгаан	69,216,000.00	66,061,094.43	3,154,905.57	95.4
Түлш, халаалт	11,365,100.00	9,984,197.22	1,380,902.78	87.8
Цэвэр, бохир ус	12,900,000.00	11,367,703.00	1,532,297.00	88.1
Байрны түрээс	154,000,000.00	153,243,000.00	757,000.00	99.5
Хангамж, бараа материалын зардал	309,303,300.00	305,344,451.85	3,958,848.15	98.7
Бичиг хэрэг	89,900,000.00	90,108,630.00	(208,630.00)	100.2

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тээвэр, шатахуун	60,100,000.00	60,066,800.00	33,200.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,800,000.00	33,161,396.85	1,638,603.15	95.3
Ном, хэвлэл	16,873,600.00	14,340,000.00	2,533,600.00	85.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	800,000.00	400,000.00	66.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,429,700.00	106,867,625.00	(437,925.00)	100.4
Эд хогшил, урсгал засварын зардал	243,500,000.00	240,164,260.00	3,335,740.00	98.6
Багаж, техник, хэрэгсэл	104,000,000.00	100,696,700.00	3,303,300.00	96.8
Урсгал засвар	139,500,000.00	139,467,560.00	32,440.00	100.0
Томилолт, зочны зардал	46,500,000.00	40,367,150.00	6,132,850.00	86.8
Дотоод албан томилолт	46,500,000.00	40,367,150.00	6,132,850.00	86.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	374,987,100.00	363,157,292.00	11,829,808.00	96.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,095,800.00	323,544,736.00	6,551,064.00	98.0
Даатгалын үйлчилгээ	12,496,100.00	12,495,690.00	410.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,042,800.00	1,977,037.00	65,763.00	96.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	544,600.00	498,000.00	46,600.00	91.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,509,500.00	7,138,912.00	4,370,588.00	62.0
Газрын төлбөр	18,298,300.00	17,502,917.00	795,383.00	95.7
Бараа үйлчилгээний бусад зардал	170,860,500.00	149,019,204.00	21,841,296.00	87.2
Бараа үйлчилгээний бусад зардал	142,760,500.00	121,270,490.00	21,490,010.00	84.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,100,000.00	27,748,714.00	351,286.00	98.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,000,000.00	28,260,100.00	11,739,900.00	70.7
Бусад урсгал шилжүүлэг	40,000,000.00	28,260,100.00	11,739,900.00	70.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,000,000.00	18,000,000.00	9,000,000.00	66.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	10,260,100.00	2,739,900.00	78.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,433,004,000.00</b>	<b>5,341,199,376.21</b>	<b>91,804,623.79</b>	<b>98.3</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,163,004,000.00</b>	<b>5,008,775,926.11</b>	<b>154,228,073.89</b>	<b>97.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	5,163,004,000.00	5,008,775,926.11	154,228,073.89	97.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>270,000,000.00</b>	<b>332,423,450.10</b>	<b>(62,423,450.10)</b>	<b>123.1</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000,000.00	332,423,450.10	(62,423,450.10)	123.1
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	
Төсвийн байгууллага	1	1	-	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>112</b>	<b>94</b>	<b>(18)</b>	
Удирдах ажилтан	14	13	(1)	
Гүйцэтгэх ажилтан	52	40	(12)	
Үйлчлэх ажилтан	46	41	(5)	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	431,553,259.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	431,553,259.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	334,117,095.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	5,448,927.00
210101	Үндсэн цалин	-	5,448,927.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	681,116.00
210201	Тэтгэврийн даатгал	-	681,116.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	35,521,760.00
210401	Бичиг хэрэг	-	4,047,800.00
210402	Тээвэр, шатахуун	-	18,000,000.00
210404	Ном, хэвлэл	-	8,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,473,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	18,303,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,500,000.00
210602	Тавилга	-	7,803,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	79,551,940.00
210702	Дотоод албан томилолт	-	72,221,940.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	7,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	96,711,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	96,741,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	97,868,792.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	97,868,792.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	97,436,164.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	94,999,950.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,436,214.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	431,553,259.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	431,553,259.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	295,839,792.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	135,713,467.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 135.4 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 84.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 21.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 18.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг хүргүүлж, 10.9 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 84.5 сая төгрөгийн алдаа<sup>2</sup> илэрснээс аудитын явцад залруулсан.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шүүхийн захиргааны ажилтны сургалтад зориулан ХБНГУ-аас GIZ төслийн хүрээнд 63,400.0 мянган төгрөгийн "Сургалтын цахим систем" хийлгэснийг шууд зардлаар тайлагнасан.	1	63,400.0	-	-	1	63,400.0	1	63,400.0	-	-	-	-
Нийгмийн даатгалын шимтгэлийн 52.3 мянган төгрөгийн илүү төлөлтийг авлагаар тайлагнаагүй.	1	52.3	-	-	1	52.3	1	52.3	-	-	-	-
Санхүүгийн тайланд 21,008.0 мянган төгрөгийн авлагыг бараа материалаар бүртгэж, тайлагнасан.	1	21,008.0	-	-	1	21,008.0	1	21,008.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>84,460.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>84,460.3</b>	<b>3</b>	<b>84,460.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 50.9 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрснээс, 21.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 18.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1, хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг хүргүүлж, 10.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Тайлант онд нэр бүхий 4 ажилтанд нийт 558.5 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.	1	558.5	1	558.5	-	-	-	-	-	-
Хөрөнгийн хэсэгчилсэн биет тооллогоор 21,008.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан.	1	21,008.0	1	21,008.0	-	-	-	-	-	-
1. Мөнхийн үсэг ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр "Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолын эмхэтгэл" хийлгэх гэрээ байгуулан хөрөнгийг хүлээж аваагүй байхад 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг дүгнэсэн акт үйлдэн, бараа материалд орлого авч, гүйцэтгэгчид 19,908.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. 2. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын актаар хүлээж аваагүй байсан 21,008.0 мянган төгрөгийн хөрөнгийг байгаагаар тоолсон.	1	-	-	-	-	-	-	-	1	2
Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2023 оны Б/36 дугаар, А/116 дугаар тушаалаар цалингийн зардлаас шинэ санал санаачилга гаргасан албан хаагчдад 18,425.1 мянган төгрөгийн шагналыг олгосон.	1	18,425.1	-	-	1	18,425.1	-	-	-	-
Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн авто тээврийн хэрэгсэл 1,168,560.0	1	-	-	-	-	-	1	-	-	-

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянга, машин тоног төхөөрөмж 1,125,200.9 мянга, тавилга эд хогшил 351,623.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 27,041.9 мянга, программ хангамж 273,335.4 мянга, нийт 2,945,761.2 мянган төгрөгийн үнэ бүхий 421 нэр төрлийн 1,324 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байна.										
Ажилтнуудад олгосон 3,600.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.	1	3,600.0	-	-	-	-	1	3,600.0	-	-
Төсвийн хөрөнгөөр 7,330.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	1	7,330.0	-	-	-	-	1	7,330.0	-	-
Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 22,376.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>50,921.6</b>	<b>2</b>	<b>21,566.5</b>	<b>1</b>	<b>18,425.1</b>	<b>4</b>	<b>10,930.0</b>	<b>1</b>	<b>2</b>

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс 2 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Захиргааны хэргийн шүүхийн албан конторын барилгын газрыг эзэмших эрхийн гэрчилгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 16 авто тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>